



Хэнтий аймгйн Улсын
бүртгэлийн хэлтэс

ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 ОН

**ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГИЙН АГУУЛГА**

1. Бодлогын зорилтыг хангах талаар.
 - 1.1. Удирдлага зохион байгуулалт
 - 1.2. Удирдлагаас өгсөн чиглэл, үүрэг даалгаврын биелэлт;
 - 1.3. Улсын бүртгэгч нарыг удирдлага арга зүйгээр хангасан байдал:
 - 1.4. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн талаар:
 - 1.5. Нээлттэй ил тод байдлыг хангасан байдал:
 - 1.6. Мэдээллийн сангийн аюулгүй ажиллагааг хангасан байдал:
 - 1.7. Санхүүгийн үйл ажиллагаа:
2. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар
 - 2.1. Иргэний улсын бүртгэл
 - 2.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэл
 - 2.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
 - 2.4. Хяналт шалгалтын үйл ажиллагаа
 - 2.5. Архивын үйл ажиллагаа
3. Сургалт, сурталчилгааны ажлын талаар
 - 3.1. Албан хаагчдыг чадавхижуулах чиглэлээр
 - 3.2. Иргэд, байгууллага, аж ахуйн нэгж рүү чиглэсэн сургалт, мэдээлийн ажил
 - 3.3. Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан талаар:
4. Бусад ажлын талаар:
 - 4.1. АНСДИТХурлын нөхөн сонгууль-2025
 - 4.2. Орон нутгийн зохион байгуулсан ажлын талаар
5. Дүгнэлт, Санал

ХЭНТИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 12

Хэрлэн

НЭГ:БОДЛОГЫН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ТАЛААР.

1.1. Удирдлага, зохион байгуулалт:

Улсын бүртгэлийн байгууллага нь 2025 оныг “Төрийн бүтээмж, нийгмийн баталгааг хэрэгжүүлэх жил” болгох зорилтын хүрээнд тус хэлтэс нь 40 орон тоотойгоор иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Мөн хэлтсийн нийт албан хаагчдад Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хуулийг чанд мөрдөн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний стандартыг баримтлан ажиллахыг үүрэг болгон мэргэжлийн удирдлагаар ханган, 2025 оны жилийн эцсийн энэхүү тайланд байгууллагын стратеги зорилтыг хангах зорилгоор нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээнд хамрагдсан болон хэлтсийн хэмжээнд хийгдсэн ажил, улсын бүртгэгч нарын хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг нэгтгэн танилцуулж байна. Үүнд:

ХЭЭХЭУБТасгийн улсын бүртгэгч Ч.Ууганбаяр нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаж УБЕГ-ын даргын Б/261 тушаалаар чөлөөлөгдсөн. Мөн хүүхэд асрах чөлөө авсан Хэрлэн сумын бүртгэгч Ч.Ганпүрэв нь үүрэгт ажилдаа эргэн орох хүсэлтээ өгч, Жаргалтхаан сумын улсын бүртгэгч жирэмсний амралтаа авч, Бэрх тосгоны улсын бүртгэгч хүүхдээ эмчлүүлэх 3 сарын чөлөө авч, бүгд эргэн ажилдаа орж хэвийн бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна.

Албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр жил бүр тухайн жилийн 1 дүгээр улиралд багтаан улсын бүртгэгч нарт албан бичгээр чиглэл, зөвлөмж хүргүүлсэн

Тус хэлтсийн улсын бүртгэгч нарын 2025 оны хагас жилийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшин үнэлэх журам”-ын дагуу байгууллагын Хяналт шинжилгээ, үнэлгээний багийн бүрэлдэхүүн хэлэлцэж, үнэлгээ хийсэн.Улсын бүртгэгч нарын 2025 оны хагас жилийн дундаж үнэлгээ 83.14 хувь буюу хэвийн дүгнэгдэв. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, тайлан бичихдээ анхаарах асуудлаар улсын бүртгэгч нарт жил бүрийн 1, 3 дугаар улиралд зөвлөмжийг цахимаар болон албан бичгээр хүргүүлж хэвшсэн.


Тайлангийн хугацаанд орон нутагт хуулийн этгээд, эд хөрөнгө эрхийн улсын бүртгэл хөтөлж буй 15 улсын бүртгэгч нарт “хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх цаашид анхаарах асуудал бол нийтлэг гарч буй бүртгэлийн зөрчлийн талаар” сэдвээр 3 удаа чадавхжуулах болон дадлагажуулах сургалтыг хэлтсээс зохион байгуулж бүртгэгч нарыг бүрэн 100 хувь хамруулаад байна.

Тайлангийн хугацаанд тус хэлтэст ирсэн албан бичиг 1467, явуулсан албан бичиг 593 байна. Албан бичиг хөтлөхдөө, Erp.e-mongolia.mn, төрийн цахим шуудан зэрэг программ, цахим хаягуудыг бүрэн ашиглаж байна.

Тайлангийн хугацаанд хэлтэст улсын бүртгэлтэй холбоотой 22 өргөдөл, хүсэлт гаргасны 20 нь иргэдээс, 2 хэлтсийн албан хаагчдаас ирсэн байна. Ирүүлсэн 22 өргөдөл,гомдол хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу 100 хувь шийдвэрлэн хариу өгч, тайлант судалгааг сар, улирал бүр naranchimeg.a@burtgel.gov.mn хаягаар нийт 10 удаа хүргүүлж ажилласан.

Иргэний улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийн санд нөхөн бүртгэх, нэмэлт өөрчлөлт оруулах 224 иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох арга хэмжээ авч, мэдээллийн санд нөхөн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийг тусган ажилласан.

Дохиолол хамгааллын системийг 2025 оны 07 сарын 31-нд “Классик сити” ХХК компани нь тоног төхөөрөмжийг суурьлуулж 2025.09.08-аас хэвийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн. Одоогийн байдлаар зөрчил дутагдал гараагүй болно.



1.2. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт

Ерөнхий газраас болон бусад байгууллагаас ирүүлсэн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын биелэлтийн талаар:

Тайлангийн хугацаанд УБЕГ-ын даргын Б/196, Б/197, А/67, А/116 дугаар тушаал, УБЕГ-ын ИУБГ-аас ирүүлсэн 3/432, 3/1017, 3/8699, 3/10648, 3/11026 тоот албан бичиг, ТГ-ын 2025 оны 2/3492, 2/522, 2/6276, 7/7977, 1/8305, 7/8895, 9/10010, 1/10374, 1/10658, 9/11600, 5 дотоод албан бичгийг тухай бүр холбогдох албан тушаалтанд танилцуулж, судлуулж бүртгэлээр хяналт тавин хэрэгжилтийг ханган ажилласан. Тушаал шийдвэр, чиглэл, үүрэг даалгаврын хүрээнд дараахь ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- ИУБГ-аас ирүүлсэн 2025.01.09-ний өдрийн 3/432 тоот албан бичгийн дагуу иргэний үнэмлэхний 338 иргэний жагсаалт ирүүлснийг хэвлэлтийн мэдээллийг тулган шалгаж энэ тухай илтгэх хуудсыг ИУБГ-т хүргүүлсэн.
- АНСДИТ-ын 2025 оны нөхөн сонгуулиар улсын бүртгэлийн хэлтсийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны 27 заалт бүхий дэд төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.
- Нийт улсын бүртгэгч нарт иргэний үнэмлэхийн бүртгэлийг хөтлөхөд анхаарах асуудлын талаар чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн энэ талаарх сургалтыг улсын бүртгэгч нарт цахимаар зохион байгуулсан.
- УБЕГ-ын Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтэд тусгах саналыг холбогдох газарт хүргүүлсэн.
- Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд 10, болон Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд 14 тусгах саналыг тус тус нэгтгэн хүргүүлсэн.
- УБЕГ-ын даргын 2025.04.11-ний өдрийн А/67 дугаар тушаалаар аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал зэрэглэл шинэчлэн батлагдсантай холбоотой сонсох ажиллагааг зохион байгуулж, сонсох ажиллагаа зохион байгуулсан тухай тэмдэглэл, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй

оролцогчдын тайлбар саналыг заасан хугацаанд Тамгын газарт хүргүүлсэн.

- Даргын зөвлөлийн хурал №3-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан тайланг хүргүүлсэн.
- 2025.05.12-05.13-ны өдрүүдэд иргэний улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгчийн хамт УБЕГ-т мэргэжил арга зүйгээр хангах чиглэлийн сургалтад хамрагдсан.
- Хэлтсийн даргын чөлөөтэй байх хугацаанд 4 удаа улсын ахлах бүртгэгч түр орлон гүйцэтгэж байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулсан.
- Нөхөн сонгууль болсонтой холбогдуулан УБЕГ-ын даргын 2025 оны А/116 дугаар тушаалаар нөхөн сонгууль болсон 6 сумын иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сэргээсэн.
- 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь гаргаж хэлтсийн даргад тайлагнасан.
- УБЕГ-ын 2025 оны 1/8305 албан бичгийн дагуу зөвлөмжийг албан хаагчдад цахимаар болон танхимаар танилцуулга хийж, чиглэл өгсөн.
- УБЕГ-ын ёс зүйн дэд хорооноос ирүүлсэн “Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны “Ёс зүйтэй хамт олон”-ыг шалгаруулах тухай удирдамжийн дагуу хэлтсийн албан хаагчдын дунд явган аялал, “Өнгөний өдөр” нөлөөллийн ажил зохион байгуулсан.
- УБЕГ-ын 2025.09.03-ны өдрийн №02 удирдах ажилтны шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гарган 2025.09.30 нд хүргүүлсэн.
- ИУБГ-аас ирүүлсэн 3/11026 албан бичгийн дагуу иргэний улын бүртгэлийн мэдээллийн сангаас бүртгэлийн дэвтэр хэвлэхэд холбогдох 3 саналыг хүргүүлсэн.
- “Улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ” зохион байгуулах арга хэмжээний удирдамжийн дагуу 35 иргэний хүсэлтийн дагуу байгаа газарт нь очиж явуулын үйлчилгээ үзүүлсэн.

1.3.Улсын бүртгэгч нарыг удирдлага арга зүйгээр хангасан байдал:

ZOOM мэдээллийн цагийн хуваарийн дагуу 14 хоног тутамд буюу тайлант хугацаанд 25 удаа сумдын улсын бүртгэгч нарт мэдээ, мэдээлэл, чиглэл өгч удирдлага арга зүйгээр тогтмол ханган ажиллаж байна.

Улсын бүртгэгч нарт 4 удаагийн чиглэл өгөх сургалтыг зохион байгуулж удирдлага арга зүйгээр ханган ажилласан. Үүнд: Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахтай холбоотой, лавлагаа, мэдээлэл олгохтой холбоотой, удирдах ажилтны зөвлөгөөний танилцуулга хичээл, нөхөн сонгуультай холбоотой гэх мэт.


Улсын бүртгэгч нарт 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний арга хэмжээг нэг бүрчлэн танилцуулж, хэрэгжилтийг хэрхэн хангах, тайлагнах талаар зөвлөмж чиглэлийг цахимаар өгсөн.

Улсын бүртгэгч нарт цахимаар 4 удаа Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг хүргүүлж, нэмэлт мэдээлэл өгч ажилласан.

Хэлтсийн Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний дагуу “Хүний эрх ба ёс зүй” сэдвээр албан хаагчдад сургалт зохион байгуулсан.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ажлын байранд хөрвөн ажиллах чадвар эзэмших мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилтын хүрээнд улсын ахлах бүртгэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн и-бизнес системд нэр баталгаажуулах бүртгэл хийхэд суралцан мэдлэг чадвараа дээшлүүлсэн. Тасгийн улсын бүртгэгч нар өдөр тутамдаа эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд шаардагдах нотлох баримт, бусад мэдээллийг бие даан суралцаж байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчидтай явцын ярилцлагыг зохион байгуулж гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангуулах үүрэг даалгаврыг өгсөн.



1.4. Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн талаар:

УБЕГазрын даргын Б/258 тоот тушаалаар 1 албан хаагчдад эрүүл мэндийг дэмжиж мөнгөн урамшуулал олгосон. Бэрх тосгоны улсын бүртгэгчид 3 сарын цалинтай чөлөө болон турк улсын онгоцны 2 талын тийзний зардлыг тус тус олгосон.

Ахмадын сан байгуулж Хэлтсийн даргын А/04 дугаар тушаалаар ахмадын сан байгуулж 21.700.000 төгрөгийг төвлөрүүлээд байна. Сар шинийн баяраар 7 ахмад ажилтанд 350 000 төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн. Ахмад ажилтнууддаа 2025 оны 10 сарын 03-ны өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүллээ. Нийт 8 ахмадад гарын бэлэг гардуулсан.



Төрийн захиргааны 4 албан хаагчдын 5 жилийн тэтгэмж авах судалгааг гаргаж Сангийн яамруу албан бичиг хүргүүлж зардлын эрхийг тавиулсан. Хэлтсийн даргын Б/05 тоот тушаалаар 4 албан хаагчдад 34 847 748 төгрөгийн тэтгэмжийг олгосон. 2026 онд 1 албан хаагчийн хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 жилийн тэтгэмжийн судалгааг УБЕГ-т хүргүүлээд байна.

Тус хэлтсийн 14 албан хаагчид болон тэдний гэр бүлийн 5 насанд хүрсэн гишүүдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, эрт илрүүлэг хийх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээнд Төрийн албан хаагчдын тусгай эмнэлгийн үзлэгт хамрагдаж 3 албан хаагчийг хоёрдугаар шатлалын эмнэлэгт хандаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авахаар болоод байна. Нийт албан хаагчдын 86 хувь нь үзлэгт хамрагдсан байна.

Орон сууцны ипотекийн зээлд хэрхэн хамрагдах талаар Хасбанктай хамтран албан хаагчдад мэдээ мэдээлэл өгсөн. УБЕГазраас орон сууцны захиалга авахад нягтлан бодогч Б.Ганцэцэг хамрагдсан



■ Хэлтсийн “Хүүхдийн өрөө”-нд албан хаагчид өөрсдийн нөөц боломжоор номын тавиур байрлуулж 20 ширхэг ном хандивласан. Мөн УБЕГ-аас явуулж буй ХБИ-ийн эрхийг хангах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний гаргаж буй хүүхдийн номноос дэмжлэг үзүүлж 4 ном худалдан авсан.

■ Бага насны хүүхэдтэй эцэг эхэд хүүхдээ сургууль цэцэрлэгт хүргэж өгөх, авах, эргүүлд гарах, эцэг эхийн хуралд очих зэрэг цагийг зохицуулж 5 албан хаагчдад ажлаас чөлөө олгож ажилласан. Албан хаагчдын 73 хүүхдэд эх үрсийн баяраар 2 920 000 төгрөгийн бэлэг өгсөн. ЕБС-ын 12-р ангиа амжилттай төгсөж байгаа албан хаагчдын 4 хүүхдэд хэлтсийн зүгээс талархал хадгалуулсан.



“Улаан бурхан” өвчлөлөөс сэргийлэх хүрээнд Хэлтсийн 22 албан хаагчдад дархлаа дэмжих витамижуулалт олголоо.




Хэлтсийн дарга Б.Төрхүү Олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрх зүйн эчнээ ангид суралцаж 120 кр цагийг судлан эрх зүйч мэргэжилээр төгсөн Бакалаврын зэрэг авсан.



1.5.Нээлттэй ил тод байдлыг хангасан байдал:

Байгууллагын пэйж хуудсанд тайлант хугацаанд постер 243 , үүнээс видео бичлэг 62, текст 27, зурган постер 154, цахим хаяг www.khentii.burtgel.gov.mn/ сайтад улсын бүртгэлтэй холбоотой 57 мэдээлэл нийтлэн нийт 349 мэдээ мэдээлэл, байршуулсан. Пэйж хуудас дагагчийн тоо 1,6К, Хандалтын тоо 28388 байна

Хэлтсийн үйлчилгээний танхимд албан хаагчдын танилцуулга, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүрдүүлбэр мөн цахим мэдээлэлтэй танилцах боломжтой дэлгэцийг байршуулан ажилласан.



**Хэнтий аймгийн Улсын
бүртгэлийн хэлтэс**

1.6K followers • 7 following

Following

Message

Search

Байгууллагын пэйж хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 243 мэдээ мэдээлэл, видео шторк байршуулсан. Иргэний улсын бүртгэлийн талаар болон суманд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээг авч эхэлсэнтэй холбоотой, авлигын эсрэг хуулийн хориглох заалт гэх мэт мэдээллээр 11 удаа зурган постер бэлтгэн байршуулсан.



Иргэд бүртгэлийн үйлчилгээг цахим орчинд авах боломжийг бүрдүүлж хэлтсийн байрны үүдний хэсэгт Бүртгэлийн цахим үйлчилгээ 24/7 буланг тогтмол ажиллуулж иргэдэд 24 цагаар үйлчилгээ үзүүлж байна. Улсын бүртгэлийн цахим бүртгэлийн машинаар энэ онд 2243 тоон гарын үсэг олгосон.

“E-mongolia” цахим системээр гадаад паспорт 22, иргэний үнэмлэх 80, шилжин ирсний бүртгэл 25 иргэн хүсэлт илгээж үйлчилгээ авсан байна. Цахим төлбөрийн киоск машинаар бүртгэлийн үйлчилгээний төлбөр хураамж төлөх үйлчилгээг 4894 иргэн үйлчилгээ авсан байна.



Хэлтсийн киоск машин



Бор-Өндөр сумын киоск машин

Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэд шуурхай чирэгдэлгүй, цаг хугацаанаас үл хамаарч авах нөхөцлийг бүрдүүлэх зорилгоор хэлтсийн байранд “24/7 цахим үйлчилгээ” буланг энэ оноос ажиллуулж эхэлснээр 24 цагаар бүртгэлийн киоск машинаас үйлчилгээ авах, төлбөр хураамж төлөх бүрэн боломжтой болсон нь иргэдэд таатай үйлчилгээ болсон. Мөн дээрх үйлчилгээг Бор-Өндөр суманд нээн ажиллуулж үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.


1.6.Мэдээллийн сангийн аюулгүй ажиллагааг хангасан байдал:

УБЕГ-аас бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах системийн өөрчлөлт, шинэчлэлтүүдийг үе шаттайгаар хийж албан хаагчдыг чадавхжуулах, дадлагажуулах сургалтыг танхимаар болон онлайнаар зохион байгуулж хэлтсийн албан хаагчид бүрэн хамрагдаж байна.


Бүх сумдын иргэний улсын бүртгэлийн онлайн системийн клиент программууд шинэчлэгдэж тухай бүрд нь бүртгэгч нэг бүрд заавар зөвлөгөөг давхардсан тоогоор 432 удаа өгч ажиллагаанд оруулж хэвийн ажиллаж байна. Улсын бүртгэгчдийн бүртгэл хийхэд хэрэгцээт программуудыг суулган бүртгэлийн үйлчилгээ хэвийн явагдаж байна.

Байгууллагын мэдээллийн сан, сүлжээний аюулгүй байдал гадны халдлагаас хамгаалах ажлын хүрээнд УБЕГ-аас FORTINET router 1, мэдээлэл технологийн албан хаагчийн шаардлагатай сүлжээ болон засварын тоног төхөөрөмж 1 багц, албан хаагчдын ажиллах нөхцөл тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулж 6 ширхэг dell latitude 3450 Notebook 6 ширхэг, мөн аймгийн засаг даргын тамгын газраас хэлтсийн үйл ажиллагааг дэмжиж 6 ширхэг dell core ultra i5 суурин компьютер, 2 ширхэг Dell pro 1650 notebook, Epson 3 үйлдэлт өнгөт принтер 1 ширхэг, хэлтсээс 4 оролт бүхий SWITCH 2 ш, CONVERTER 2 хос ширхгийг тус тус авч хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна. Мөн улсын бүртгэгч нарын ашиглаж байгаа бүртгэлийн программ хангамжид өөрчлөлт шинэчлэлийг давхардсан тоогоор 432 удаа тухай бүр холбогдон заавар зөвлөмж өгч, хяналт тавин ажилласан.


УБЕГ-аас иргэн, эд хөрөнгийн цахим системд шинэчлэл, хөгжүүлэлт хийж байгаатай холбоотой /update/ 4 удаа хийн ашиглалтад оруулан хяналт тавин ажиллаж байна.



УБЕГ-аас олгосон notebook
төхөөрөмж



сүлжээ болон засварын тоног




➤ УБЕГ-аас олгосон notebook

УБЕГ-аас иргэн, эд хөрөнгийн цахим системд шинэчлэл, хөгжүүлэлт хийж байгаатай холбоотой /update/ 4 удаа хийн ашиглалтад оруулан хяналт тавин ажиллаж байна. Хэлтсийн үйл ажиллагаанд ашиглах иргэд олон нийтэд мэдээлэл түгээх зорилгоор 42 инч ухаалаг телевиз 1 ширхгийг авч хурлын зааланд суурилуулан ажиллуулж байна.

Хос converter 1 ширхэг



Сумдын улсын бүртгэгч нарын бүртгэлийн үйлчилгээнд ашиглах зөөврийн 4g төхөөрөмжийг холбогдох компанитай гэрээ байгуулан хүлээн авч сумдад хүлээлгэн өгөөд байна. Тус төхөөрөмжийг 13 сум хүлээн аван тус бүртэй нь нэг бүрчлэн холбогдон ажиллах нөхцөлөөр хангаж заавар зөвлөгөөг өгч ажиллаж байна.



УБЕГ-аас иргэн, эд хөрөнгийн цахим системд шинэчлэл, хөгжүүлэлт хийж байгаагаар холбоотой /update/ 4 удаа хийн ашиглалтад оруулан хяналт тавин ажиллаж байна. Хэлтсийн улсын бүртгэлийн мэдээллийн санд ажиллаж байгаа 30 албан хаагчийн программын нэвтрэх нэр, нууц үгийг сар бүр тогтмол солиулж хэвшсэн.

Хэлтсийн төрийн захиргааны жинхэнэ албан хаагч 34 ажилтнаас 2024 оны “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг”-ийг цаасан хэлбэрээр гаргуулан авч, сайтад бүртгүүлэн ХАСХОМ-ийн нэгдсэн тайланг хүргүүлсэн.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хөрөнгө орлогын мэдүүлэгт их хэмжээний өөрчлөлт орсон 1, тушаалд өөрчлөлт орсон 1 албан хаагчийн ХАСХОМ-ийг хугацаанд нь мэдүүлж ажилласан. Мөн хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчил үүсэн тухай мэдэгдэл 21 албан хаагчаас гаргуулан авч ажилласан.

АНСДИТХ-ийн нөхөн сонгуульд итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах 7 албан хаагчдад төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжийг танилцуулж нууцын баталгааг гаргуулан авч ажилласан. Тагнуулын хэлтсээс АНСДИТХ-ын нөхөн сонгуулийн хэсгийн хороонд ажиллахад татгалзах зүйлгүй дүгнэлтийг авсан болно. Нөхөн сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудад төрийн болон албаны нууцын тухай хуулиар Тагнуулын хэлтсээс сургалт авахаар төлөвлөж байна.

Хэлтсийн нууц хамгаалах ажилтан Б.Төрхүү нь ээлжийн амралтын хугацаанд гадаад оронд аялах тухайгаа Тагнуулын газарт болон УБЕГ-ын ТГ-т урьдчилан мэдэгдэж холбогдох журмын дагуу чөлөө, зөвшөөрлийг авсан болно.

1.7. Санхүүгийн үйл ажиллагаа:

Санхүүгийн тайлганалын талаар: 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн бусад холбогдох хууль журам зааврын дагуу гаргаж 2025.02.25 өдөр Хэнтий аймаг дахь аудитын газарт түүвэрт хамрагдаж ямар нэгэн зөрчил илэрээгүй.. УБЕГ газарт нэгтгүүлэн, Сангийн яамны “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан” онлайн програмд шивж жилийн эцсийн санхүүгийн тайлангаа цаг хугацаанд нь хүлээлгэж өглөө.

Татварын хэлтэст 2024 оны бүтэн жилийн 4 төрлийн тайлангаа цаг хугацаанд нь цахим хэлбэрээр хүлээлгэн өгсөн.

Монгол улсын сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын дагуу төсвийн шинэчилсэн ангилалыг мөрдлөг болгон ажиллаж байна. Төсвийн тухай хуулийн

16.5.7 заалтын дагуу 2025 онд 10 төрлийн мэдээг цаг хугацаанд нь гаргаж УБЕГазарт хүргүүлээд байна. Санхүүгийн үйл ажиллагаанд 18 төрлийн нэгдсэн системд программд нэвтрэн орж үйл ажиллагааг гүйцэтгэж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар: Монгол улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”- д Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг тухай бүр, сар бүр, улирал тутам гаргаж УБЕГазрын хяналт үнэлгээ шинжилгээ дотоод аудитын газарт илгээж ажиллаа.

Шилэн дансны нэгдсэн системд 2025 оны 10 сарын байдлаар нийт 139 мэдээллийг хуулийн хугацаанд нь цахим болон мэдээллийн самбарт байршуулсан.

“Байгууллагын админ эрх”-ээр 1-р улирлын тайланг 2025 оны 04 дүгээр сарын 04-нд, 2-р улирлын тайланг 07 дугаар сарын 03-нд, 3 дугаар улирлын тайланг 10 дугаар сарын 08-нд илгээж цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан.

№	Тайлангийн нэр	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах хугацаа	Тайлан оруулах хэрэглэгч	Завчлаа эсэх	1	2	3	4
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмжээний шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БОЛД ГАНЦЛЭХ		✓	✓	✓	✓
2	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл - Хөтөлбөр, зориулалт	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БОЛД ГАНЦЛЭХ		✓	✓	✓	✓
3	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл	Гүйцэтгэл	дараа сарын 8-ны дотор	БОЛД ГАНЦЛЭХ		✓	✓	✓	✓
4	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	Тухай бүрийн төрөл	дараа сарын 8-ны дотор	БОЛД ГАНЦЛЭХ		✓	✓	✓	✓

№	Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр	Мэдээлэл оруулах давтамж	Нийт мэдээлэх	Хугацаандаа мэдээлэх	Хугацаа хоцорч мэдээлэх	Мэдээлэл байршуулагүй	Монгол дүн
1	Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмжээний шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал	Сар бүр	3	3	0	0	Батлагдсан төсөв, жилээр: 1,210,382,200 Батлагдсан төсөв, тайлант үйлдвэрлэл /Олсон дүнгээр/: 323,302,900 Батлагдсан төсвийн гүйцэтгэл /Олсон дүнгээр/: 304,831,713.67 Хэтрэлт, хэмжээ /Олсон дүнгээр/: 10,471,186
2	Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт	Сар бүр	3	3	0	0	
3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	Жил бүр	1	1	0	0	Төсвийн өртөг: 13,860,000
4	Худалдан авах ажиллагааны тайлан	Жил бүр	0	0	0	0	

Төсвийн ил тод нээлттэй байлын талаар: Засгийн газрын 2012 оны 17 дугаар тогтоол “Төсөв санхүүгийн ил тод байдлыг хангах” журмын хэрэгжилтийн хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн санхүүгийн мэдээллийг мэдээллийн самбарт

сар бүрийн төсөв, гүйцэтгэлийг өссөн дүнгээр гарган иргэд, болон олон нийтэд нээлттэй хүргүүлж байна.

Төсвийн ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор төсвийн байгууллагын төсвийн мэдээллээ Сангийн яамны шилэн дансны нэгдсэн цахим сайт болон мэдээллийн самбараар мэдээллэх ажил тогтмолжсон.

2025 оны 10-р сарын байдлаар 1 336 446 700 төгрөгийн төсөв батлагдан ирснийг Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтаар батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай 1 314 543 669 төгрөгийн гүйцэтгэлтэйгээр зарцуулан ажилласан. Нөхөн сонгуулийн явуулах ажлын хүрээнд дээд шатны төсвөөс 8 867 500 төгрөг шилжин ирсэнийг зориулалтын дагуу 100 хувь зарцуулсан. Хэлтсийн даргын 2025 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн А/02 тушаалаар ахмдан сангийн зөвлөл байгуулагдаж ахмадын сантай болсон. Ахмадын сангийн дансанд 21 700 000 төгрөгийг төвлөрүүлж ахмадын баяраар 5 640 000 төгрөгийг зарцуулсан.

Үнэт цаас зарцуулалтын талаар: Үнэт цаасыг бүртгэгч нарт хатуу дугаарын дагуу журнал хөтлөн олгож үнэт цаасны нэгдсэн программд бүртгэгч тус бүрээр хувиарлаж хэвшсэн.

Үнэт цаас татан авах тайлагнах журмын дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас 15710 ширхэг гэрчилгээ маягт татан авсан, улсын бүртгэгч нарт 16017 ширхэг гэрчилгээ маягт зарцуулсан байна. Сумдын болон хэлтсийн улсын бүртгэгч нараас сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон үнэт цаасны тайланг цаг хугацаанд нь авч сум бүрээр нэгтгэн УБЕгазарт хүргүүлж хэвшсэн. 2025 оны 10 сарын байдлаар хүчингүй үнэт цаас нийт 215 ширхэг хүчингүй үнэт цаас гаргасан байна.


Үндсэн хөрөнгө ашиглалтын талаар: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг хариуцсан албан хаагчдад эд хогшилын карт хөтлөн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дотоод албан хэрэгцээнд 2011 онд ашиглалтанд орсон 1 ширхэг, 58 000 000 төгрөгийн nissianxtrial маркийн авто машиныг хэрэглэдэг. Уг авто машин нь элэгдэлээ нөхөж ашиглах хугацаа дууссанаас шалтгаалж хөдөлгүүрийн тахир гол, шатуны болон хий хуваарилах механизмын ажиллагаа, тосны даралт заагч, тосолгоо тэжээлийн системийн битүүмжлэл зэрэг эд ангиуд эвдэрч гэмтсэн, засвар үйлчилгээ авах боломжгүй болсон тул актлуулах Автотээвэр хэрэгслийн техникийн дүгнэлт №04 гаргуулан УБЕГазар болон Төрийн өмч бодлого зохицуулалтын газарт хүргүүлж 2025 оны 09 дүгээр сарын 440 тоот тогтоолоор нээлттэй дуудлага худалдаанд оруулж байна.. Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 77 хувьтай дүгнүүлэн ажилласан.

Хөрөнгө оруулалтын талаар: Аймгийн Засаг даргын 2025 оны А/224 тоот захирамжаар 30 000 000 төгрөгийн тоног төхөөрөмж авах зардал шийдэгдэж 3 нэр төрлийн 9 ширхэг тоног төхөөрөмж ирсэн. УБЕгазраас 1 ширхэг суурин компьютер, 1 ширхэг скайнер татан авчирсан. 14 сумын 4г төхөөрөмжийн гэрээг Итгэлт төмөр хэлхээ ХХК-тай байгуулан тоног төхөөрөмжийг татан авчирсан. УБЕгазраас 6 ширхэг зөөврийн компьютер татан авчирч сумдад хүлээлгэн өглөө.Төсвийн хөрөнгөөр тоос сорогч 270 000 төгрөгөөр худалдан авсан.

Орлого төвлөрүүлтийн талаар: Засгийн газрын 2010 оны 237 тогтоолоор тогтоосон үйлчилгээний хөлсний хураамж нь 10 сарын байдлаар 151 342 102 төгрөгийн орлого төвлөрсөнийг бүртгэл тус бүрээр харьцуулсан нь


Орлогыг бүртгэл тус бүрээр харуулсан байдал



Байгууллагын дансанд төвлөрдөг улсын төсвийн орлогыг сүүлийн 3 жилээр харьцуулахад Киоск цахим төлбөрийн машинаар тушаалгадаг үйлчилгээний орлогыг 100180012008 тоот дансанд шууд төвлөрдөг болсон ба эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн өндөр дүнтэй бүртгэлтэй холбоотой өссөн харагдаж байна.



Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогыг харьцуулахад үл хөдлөх хөрөнгийн татварын орлогын дүн ихэнх хувийг эзэлж байна.



2025 оны 10 сарын байдлаар Орон нутгийн төсөвт бүртгэлийн тэмдэгтийн хураамж 58 920 559, Эд хөрөнгө худалдан борлуулсаны орлого 386 442 118 төгрөг, торгуулийн орлого 200 000 нийт 137 659 082 төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. Улс болон орон нутгийн төсөвт нийт 445 562 677 төгрөгийн орлого төвлөрүүлээд байна.



Хүний нөөцийн талаар: Улсын бүртгэлийн хэлтэс нь нийт 42 орон тоотой ажиллаж байна. Үүнээс: төрийн захиргааны албан хаагч -33, төрийн үйлчилгээний албан хаагч -4, гэрээт-5 албан хаагч ажиллаж байна. Албан хаагчийг хүйсээр харьцуулбал эрэгтэй-11, эмэгтэй-31

2025 оны 09 дүгээр сарын А/157 тоот тушаалаар бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөн. Нийт орон тоо 40 үүнээс: Төрийн захиргааны-31, төрийн үйлчилгээ-5, Гэрээт-2 ажиллаж байна. Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд 5 гэрээт албан хаагчийн үндсэн цалин, 37 албан хаагчийн цалингийн шинэчлэлтийг тогтоолийн дагуу, ажлаас чөлөөлөгдсөн 2 албан хаагч, зэрэг дэвийн нэмэгдэлийн 9 албан хаагч, данс мэдээлэл 4 албан хаагч, 3 албан хаагчийн майл хаяг, ажлаас чөлөөлсөн 8 албан хаагч, шинээр ажилд орсон 1 албан хаагч, хүүхэд асра чөлөө дуусгавар болсон 2 албан хаагчийн мэдээлэлийг тус тус тухай бүр шинэчилсэн.


Хэлтсийн дарга, улсын ахлах бүртгэгч, улсын бүртгэгч, төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг оруулсан.

Нийт 40 орон тоогоор ажиллаж байна. Төрийн албан портал системд 35 албан хаагч мэдээлэлээ баталгаажуулсан.

Албан хаагчдын төрд ажилласан жил Албан тушаалын төрлийн байдал




Албан хаагчдын цалингийн шатлал Албан хаагчдын мэргэжилийн байдал



Хүйсээр харьцуулсан байдал



Насны ангилалаар харьцуулсан байдал



Нийт албан хаагчдыг насаар харьцуулвал 35-44 насныхан дийлэнх хувийг эзэлж байна.

ХОЁР: УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР.

Бүртгэлийн чиглэлээр:

Хоёр. Бүртгэлийн чиглэлээр:


2.1. Иргэний улсын бүртгэл. Тайлангийн хугацаанд иргэний улсын бүртгэлийн нийт 9662 бүртгэлийг хөтөлж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу нягтлан шалгаж иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд шивж, эх нотлох баримтыг цахимжуулан, баталгаажуулсан. Үүнд:

1. Төрөлт-916
2. гэрлэлт 238
3. Гэрлэлт дуусгавар болсны 71
4. хүүхэд үрчлэлт 21
5. овог нэр өөрчлөлт 48
6. эцэг тогтоолт 46
7. нас баралт 402
8. Иргэний үнэмлэх 2920
9. Гадаад паспорт 3306
10. Шилжилт хөдөлгөөн 1694






2.2. Лавлагаа олголт: Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 10057 лавлагаа олгосон байна. Үүнд: Холбогдох хууль журмын дагуу хууль хяналтын байгууллагад хүсэлт албан бичгийн дагуу иргэний улсын бүртгэлтэй холбоотой 1134 лавлагаа, иргэний хүсэлтээр иргэний улсын бүртгэлтэй холбоотой 7785 лавлагаа, иргэний улсын бүртгэл хөтлөхдөө албан хэрэгцээнд зориулж 1138 лавлагааг тус тус олгосон.



Сумдын улсын бүртгэгч нараас бүртгэлийн тоон мэдээг сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон авч нэгтгэн Иргэний улсын бүртгэлийн газарт j.narantuya@burtgel.gov.mn хаягаар хугацаанд нь 10 удаа хүргүүлэн ажилласан.

2.3. Нөхөн болон нэмэлт өөрчлөлтийн бүртгэл, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүртгэл хүчингүй болгосон бүртгэл

Улсын ахлах бүртгэгч 562 нэмэлт өөрчлөлтийг ХШГ-ын хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд өөрчлөлтийг оруулсан. Иргэдийн ургийн овгийн мэдээлэл зөрүүтэй, эцэг, эхийн мэдээлэл тусгагдаагүй, гэрлэлтийн бүртгэл цахим мэдээллийн санд тусгагдаагүй, үндсэн сангийн гэрлэлтийн төлөв буруу гэх мэт 224 хүсэлтийг өргөдлөөр авч шийдвэрлэв. 40 иргэний улсын бүртгэл нөхөн бүртгэж мэдээллийн санд тусгасан. Хэлтсийн хяналтын улсын байцаагчийн 2025 оны 124, 316 дугаар дүгнэлтээр төрсний болон гэрлэсний бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулсан.




2.4. Тоон гарын үсэг олголт.

Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд 7007 иргэний хүсэлтээр тоон гарын үсэг олгоод байна. Үүнээс иргэний үнэмлэхэнд 1372, мобайл апп-д 5635 тоон гарын үсэг олгосон. Тоон гарын үсэг олгож эхэлснээс хойш нийт 63438 иргэнд тоон гарын үсэг олгосон бөгөөд олговол зохих иргэдийн 100 хувьд нь олгосон байна. Цахим үйлчилгээ 24/7 булан ажиллуулж буй улсын бүртгэлийн цахим бүртгэлийн машинаар энэ онд 2243 тоон гарын үсэг олгосон.



2.5. Үндэсний энгийн цахим гадаад паспортын бүртгэл.

Тайлангийн хугацаанд үндэсний энгийн гадаад паспортын бүртгэл нийт 3306 бүртгэл хөтөлсөн байна. 3256 мэдүүлгийг иргэний улсын бүртгэлийн системд Е дугаарыг тэмдэглэн цахимжуулсан. Бүртгэл хөтлөх явцад 7 иргэний нэрийн латин галиг алдаатай байсныг холбогдох арга хэмжээ авч зөрчлийг арилган бүртгэж гадаад паспортыг олгосон.



2.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаа

- Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай, хуулийн хүрээнд үнэн зөв хүргэж Хуулийн этгээдийн улсын бүртгэлд нийт 2060 бүртгэл бүртгэгдсэн байна. Үүнд:

Шинээр байгуулсан хуулийн этгээд -315

Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт – 388

Оноосон нэрийн баталгаажуулалт-489


Лавлагаа хуулбар-354

Тамга тэмдэг баталгааны хуудас-422,

Татан буугдсан бүртгэл-7

Хураан авсан тамга тэмдгийн бүртгэл-85 тус тус бүртгэн санд тусгаж цахимжуулан, зохих журмын дагуу архивт шилжүүлсэн байна.

Е-business.mn цахим хаягаар хуулийн этгээдийн 1349 шинэ нэрийн хүсэлт ирснийг шалган 1054 нэрэнд татгалзсан, зөвшөөрч баталгаажуулсан 144 нэр, зөвшөөрсөн боловч төлбөр төлөөгүй тул цуцлагдсан төлөвтэй 151, тус тус шалган зохих хариуг хүргүүлсэн байна. Е-business хаягаар хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн цахим гэрчилгээ -ийг олгосон байна.



2.3. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа:

Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр: Тайлангийн хугацаанд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ авах нийт **7031** мэдүүлэг хүлээн авч **6867** бүртгэл хийсэн. Үүнээс төрөөс үнэгүй хувьчилсан газрын бүртгэл **531**, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл-**318**, шинэ орон сууцны бүртгэл **87**, төрөөс үнэгүй хувьчилсан орон сууц-4, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсгэх-**42**, өмчлөх эрх шилжих гэрээ-**1429**, бүртгэлд өөрчлөлт оруулах-**394**, барьцааны гэрээ-**2275**, барьцааны гэрээ дуусгавар **1726**, иргэн хуулийн этгээдэд **312** лавлагаа мэдээллийг олгож эд хөрөнгийн бүртгэлийн үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулж,


үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээний хураамж **169,346,968** төгрөг, ҮХЭХ борлуулсны орлогын албан татвар **461,038,398** төгрөг, тэмдэгтийн хураамж **8,172,015** төгрөг, нийт **638,557,381** төгрөгийн орлогыг улс болон орон нутгийн төсөв төвлөрүүлээд байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан /EPRS/-д “Монголын ипотекийн корпраци ОССК” ХХК-иас “Онлайн мэдүүлэг” цэсээр цахимаар ирүүлсэн **49** хүсэлтийг “барьцааны гэрээ дуусгавар болгох” мэдүүлгийг нягтлан шалгаж бүртгэлийг бүртгэсэн


Тайлангийн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Цагдаагийн газар, Шүүх, Прокурор зэрэг эрх бүхий байгууллагад 171 албан бичгээр 195 иргэн, хуулийн этгээдийн хөрөнгөтэй эсэх лавлагааг олгож, Хэнтий аймгийн СДИХАШШүүхэд шүүгчийн захирамжаар 2 удаа нотлох баримтыг гаргаж хүргүүлсэн. Хэнтий аймаг дахь ШШГГ болон Нийслэлийн ШШГГазраас ирүүлсэн 46 хөрөнгийн эрх түдгэлзүүлэх болон сэргээх тогтоолыг үндэслэн **192** эд хөрөнгөнд эрх түдгэлзүүлэх болон сэргээх тусгай тэмдэглэлийг холбогдох хувийн хэрэгт хийж, хариу албан бичгийг хүргүүлсэн .

Эд хөрөнгийн эрхийн нийт бүртгэл:

ГЭРЭЭНИЙ ЭРХИЙН БҮРТГЭЛ /2022-2025 ОН/




ӨМЧЛӨХ ЭРХИЙН АНХНЫ БҮРТГЭЛ /2022-2025 ОН/




Эд хөрөнгийн эрхийн нийт бүртгэл /2023-2025 он/


графикаар харуулбал:




Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг бүртгэлийг орон нутагт хүргэх зорилтын хүрээнд хуулийн этгээдийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх-15, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх эрх -15 сумын улсын бүртгэгчийн ирүүлсэн бүртгэлийн тоо **2017** байна. Үүнээс үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэл **132**, төрөөс үнэгүй хувьчилсан газар-**222**, гэрээний эрхийн бүртгэл-**1455**, бусад бүртгэл - **208** тус тус бүртгэл хийгдэж өмчлөх эрхийн **977** гэрчилгээ олгогдсон байна.



Барьцааны гэрээ



Газрын анхны бүртгэл



Өмчлөх эрхийн анхны бүртгэлийг сүүлийн 3 жилээр харьцуулбал:

2024 оны бүртгэлийг 2025 оны бүртгэлтэй харьцуулсан байдлаар бүртгэлийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж үзэхэд 2025 онд **6861** бүртгэл хийсэн нь өмнөх оны **6091** бүртгэл, мөн үеэс 24,5 хувиар өссөн нэг бүртгэгчид өдөрт дунджаар 6-7

бүртгэл ногдож байна. Судалгаанаас харахад барьцааны гэрээ 46,9 хувь, төрөөс үнэгүй хувьчилсан газар 25,4 хувиар өссөн үзүүлэлттэй

2.4. Хяналт шалгалтын үйл ажиллагаа:

- Тайлант хугацаанд батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын мөрөөр нийт 1935 улсын бүртгэлд хяналт шалгалт хийж 47 зөрчлийг илрүүлж, арилгуулах арга хэмжээ авсан.
 - Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.24.1, 15.24.2, 15.24.4-т заасны дагуу 105 иргэн хялбаршуулсан журмаар торгох шийтгэл ногдуулж прокурорын газраар хянуулж ажилласан. Орон нутгийн төсвийн дансанд торгуулийн орлого 2100000 төгрөгийг төвлөрүүлсэн байна.
 - УБЕГ-ын ХШГ-аас хийсэн төлөвлөгөөт шалгалтаар 47 зөрчлийг тухай бүр арилгах арга хэмжээ авч шийдвэрлэж ажилласан.
 - Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлж нийт улсын бүртгэгч нарын бүртгэсэн бүртгэлийг тухай бүр цахим системээс нотлох баримтын цахимжуулалтыг нягтлан шалгаж, бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд өдөр тутам хяналт тавьж зөвлөгөө чиглэл өгч ажиллалаа.
 - ZOOM мэдээллийн цагийн хуваарийн дагуу 14 хоног тутамд сумдын улсын бүртгэгч нарт зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хууль журмын сургалтыг 2 удаа , мэдээлэл, чиглэл өгч удирдлага арга зүйгээр тогтмол ханган ажиллаж байна.
- Регистрийн дугаар давхардсан 1 иргэний мэдээллийг шалгаж бүртгэл давхар бүртгэлтэй байсныг Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган холбогдох газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн.
 - Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих явцад иргэн хуулийн этгээдийн гаргасан өргөдөл, гомдлын дагуу иргэний 15, эд хөрөнгийн 105, хуулийн этгээдийн 1 улсын бүртгэлтэй холбоотой хяналтын улсын байцаагчийн 121 дүгнэлтийг гаргасан.

Үүнд:

	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
	Бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай	28
	Бүртгэл хүчингүй болгох тухай	69
	Бүртгэл сэргээн тогтоох	1
	Нийт	121

Бүртгэлийн төрлөөр ангилвал.

	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
	Иргэний бүртгэл	15
	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	1
	Эд хөрөнгө	105
	Нийт	121

Хяналтын улсын байцаагчаас гарсан шийдвэрийг харуулбал:

	Хяналтын улсын байцаагчийн	тоо
	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	121
	Хяналтын улсын байцаагчийн шийтгэлийн хуудас	105
	Хяналтын улсын байцаагийн мэдэгдэл	0
	Хяналтын улсын байцаагчийн акт	0

Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага	0
Нийт	226

2.5. Архивын үйл ажиллагаа

Иргэний бүртгэлийн архив: Хэнтий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/08 дугаар тушаал, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 23.2.5 дахь заалт, байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1, 7.3, 7.4 дахь заалтуудын дагуу тооллогыг хийж гүйцэтгэлээ.

Иргэний баримтын архивт иргэний 58674 хувийн хэрэг нас барсан 18496 хувийн хэрэг нийт 106005 хувийн хэрэг хадгалагдаж байна. Аймаг нийслэл рүү шилжин явсан 139 иргэн 98 хүүхэд татан авч явуулахад бэлэн болгоод байна. Шилжин ирсэн 256 иргэн 439 хүүхдийн хаатр маягтыг бүртгээд зориулалтын хайрцагт байрлуулаад байна. Архивт нийт 106005 хувийн хэргийг байрлуулаад байна.

Архивын чийг, дулаан хэмжих дэвтэр, галын хорыг хянах дэвтрээ даргаар батлуулан өдөр тутам болон сардаа хяналт тавин ажиллаж байна.

Архивын тавиурын заагуур дугаарлалт хийж дуусгасан. Мөн баяжилт хийхэд гэрэлтүүлэг муу байсан тул архивын хананд нэмэлт гэрэл хийлгэсэн. Нягтруулсан шүүгээний 2 тавиурын тавцанг тогтоох төмөр хийлгэж дуусаад байна.

Архивын 8 төрлийн нотлох баримтаа 19 сумын 164 хадгаламжийн нэгж татан авч бүртгэлжүүлж хайрцагт хийнэ дугаар олгож байрлуулаад байна. Мөн гадаад паспортын нотлох баримт улсын бүртгэгч М.Мөнхсаруулаас 11 баримт Н.Дагвадоржоос 9 баримт хүлээн авч байрлуулсан. Хяналтын улсын байцаагч О.Ганбаатараас 10 хадгаламжийн нэгж хүлээн авсан.

2024 оны хадгалах хугацаан дууссан хадгаламжийн нэгж хаатр маягтаа акт үйлдэн БНШК-оороо хуралдан 5р уурын зууханд хийж шатаасан.

Иргэний баримтын архивын 1951-2024 оны 8 төрлийн журнал болон төрөлтийн журналын гаднах цэнхэр хайрцагыг цаасан бор хайрцагаар сольж данс бүртгэл үйлдсэн





Эд хөрөнгийн Архивын чиглэлээр: : Тайлант хугацаанд архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 23.2.5, дахь заалт, байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 7.1, 7.3, 7.4 дахь заалтын дагуу явуулах хувийн хэргийн хайрцаг солих ажлыг хийж гүйцэтгэв.

Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын сан хөмрөг, хувийн хэрэг, баримтын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах үүднээс архивын өрөөний цонх, пааран талын баримт хадгалалтын шүүгээний урдуур архивын баримтийг хамгаалж ус нэвтэрдэггүй гялгар хөшиг татан хамгаалах арга хэмжээ авсан ба, таазнаас ус гоожиж баримтуудыг гэмтээх эрсдлээс урьдчилан сэргийлж тавиуруудын дээгүүр хаалт хийж тавин ажилалаа. Архивын сан хөмрөгт угсармал шар тавиур 1 ширхэгийг нэмж тавин хувийн хэргийн баяжилтыг байршуулан хэвийн ажиллаж байна.

Зураг 1. Хайрцаг солин хаягжуулсны дараах байдал



Зураг 2. Хуулийн этгээдийн архивын хувийн хэрэг цэгцэлсэн байдал



Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын сан хөмрөгт үл хөдлөх хөрөнгө /Y/ дугаартай 9666 ширхэг хувийн хэрэг, газрын /Г/ дугаартай 20876 ширхэг хувийн хэрэг нийт 30502 ширхэг хувийн хэрэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын сан хөмрөгт Хязгаарлагдмал хувьцаат компани, хоршоо, нөхөрлөл, төрийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үйлдвэрчний эвлэл зэргээс бүрдсэн нийт 3736 ширхэг хувийн хэрэг хадгалагдаж байна.

Архивын сан хөмрөгт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн шинээр анхны бүртгэл 1022 хувийн хэрэг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 315 хувийн хэргийг архивт хүлээн аван ажилласан байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивт нийслэл болон орон нутгаас шилжин ирсэн 7, шилжин явсан 7 хувийн хэрэг байна Мэдээллийн санд мэдээлэл нь зөрүүтэй иргэдийн хувийн хэрэг, болон архивын цаасан эх нотлох баримттай тулгах шаардлагатай тохиолдолд эрх бүхий албан тушаалтан хэлтсийн дарга, тасгийн дарга, хяналтын улсын байцаагч, улсын бүртгэгч нарт “Архиваас түр ашиглуулахаар олгосон нийт 100 хувийн хэргийг архивын сангаас гаргаж, буцаан хүлээн авч санд байршуулан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирсэн 2023.06.26-ны өдрийн 5/6223 тоот албан бичгээр ирсэн чиглэлийн хүрээнд архивын бүртгэлийн дэвтрүүдийг үнэн зөв бөглөж цаг тухай бүр орсон гарсан баримтуудыг бүртгэн эд хөрөнгө эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарын хувийн хэрэг нотлох баримтуудыг өдөр бүр хүлээн авч архивын сан бүрдүүлэлтийг хийн ажиллаж байна.

Байгууллагын архивын чиглэлээр:

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх зорилгоор байгууллагын архивт 1 зориулалтын тавиур шүүгээг худалдан авч баримт бичгүүдийг хадгалж байна. Баримт бичгүүдийг эмхлэн цэгцэлж, тооллогын комисс томилон бүрэн тоолж дууссан бөгөөд улсын үзлэгийн дэд комист 2025.09.22-23ны өдрүүдэд шалгуулж 84,2%-тай үнэлүүлсэн. Үзлэгийн мөрөөр үүрэг даалгаврын биелэлтийн хүрээнд баримт бичгүүдэд сэдэв зүйлийн заагч, заагуурыг байрлуулж хавтас дээрх бүрдлийг хангаж, хадгаламжийн нэгж болох 70 жил, түр хадгалах, байнгын баримт, устгах баримтын жагсаалтуудыг үлгэрчилсэн жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу гаргаж батлуулсан. Тооллогын явцад буруу үдсэн, сэлбэн засах шаардлагатай нийт 52 боть баримтыг сэлбэн зассан.

Байгууллагын архивт: 1996-2024 оны

- Устгах хэргийн баримт 175 боть -83734 хуудас
- Түр хадгалах баримт 341 боть-119388 хуудас
- 70 жил хадгалах баримт 88 боть-2174 хуудас
- Байнгын хадгалах баримт 122 боть-2664 хуудас

Нийт: 726 боть 207960 хуудас баримт хадгалагдаж байна.

Цахим архивыг D дискэнд байрлуулж хадгаламжийн нэгжүүдийг скан хийж хард дискэнд давхар хадгалж байна. Мөн байгууллагын архивын чийг дулааныг 7 хоног бүр 1 удаа, чийгтэй цэвэрлэгээг 14 хоногт 1 удаа, галын хорыг сард 1 удаа шалгаж бүртгэлийн дэвтэр хөтөлдөг.



ГУРАВ: СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫН ТАЛААР

3.1. Албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр:

2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 9 арга хэмжээ, төлөвлөн боловсруулж батлуулсан.

Хэлтсийн цахим хуудаст тавигдсан 12 авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчилсан зурган постер, мэдээ, мэдээллийг өөрийн цахим хуудаст түгээн тархааж, тогтмол идэвхжүүлэн ажиллаж байна. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэн хуулийн этгээд, албан хаагчдад сурталчлах **9 удаа** зурган постер мэдээллийг бэлдэж түгээсэн.

Хэлтсийн албан хаагчид “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үүднээс Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 4:7:10 сургалт, УБЕГ-аас зохион байгуулсан ХАСХОмын мэдүүлэг шинэчлэн гаргах, Ашиг сонирхлын зөрчлийн талаарх сэдэвт сургалтад давхардсан тоогоор 127 албан хаагчид хамрагдсан. Иргэдэд бүртгэлийн үйлчилгээг аль болох орон зай цаг хугацаанаас үл хамаарч түргэн шуурхай, чирэгдэлгүй цахимаар авах боломжтой талаар иргэдэд сурталчлах ажлыг ажлын байранд болон өдөрлөг, уулзалтад оролцох бүртээ таниулан сурталчилан ажиллаж байна. Үйлчилгээний зааланд улсын бүртгэгчийн өмнөх цонх бүрт авилгын эсрэг уриалга стикер наасан. Иргэдээс авилгатай холбоотой санал хүсэлтийн хайрцаг ажиллуулж байна.

Албан хаагчдыг чадавхижуулах сургалтын хүрээнд:


- УБЕГ-аас 2025.01.06-2025.01-15 өдөр зохион байгуулсан “Шинээр томилогдсон алба хаагчдийг мэргэшүүлэх сургалт”-ад Хэрлэн сумын улсын бүртгэгч Л.Гансүрэн танхимаар хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн.
- Авлигатай тэмцэх газраас ХАС-ын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг шинэчилэн гаргах талаар 2025.01.06-нд цахимаар зохион байгуулсан сургалтад 26 албан хаагч оролцсон.



- Аймгийн Татварын газраас “Хувь хүний орлогын албан татвар, хөнгөлөлт, чөлөөлөлт” сэдвээр зохион байгуулсан танхимын сургалтад 15 албан хаагч хамрагдсан.
- Цахим хөгжил инновац харилцаа холбооны яамнаас Төрийн ордонд зохион байгуулсан “Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги хэлэлцүүлэх, анхдугаар чуулган /data ai/” сургалтад 2025.02.13-ны өдөр мэдээллийн технологийн ажилтан оролцсон.
- УБЕГ-ын ЭХЭУБГ-аас зохион байгуулсан Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан цахим сургалтад холбогдох албан хаагчдийг хамруулсан.
- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Нэг цаг нэмэх цэнэг” эхний хагас жилийн 6 удаагийн онлайн сургалтад давхардсан тоогоор 175 алба хаагч хамруулсан.
- Хүний эрхийн үндэсний комиссын Хэнтий аймаг дахь референт Ж.Ганбаяр 2025.03.28-нд “Хүний эрхийн тухай ойлголт” сэдэвт танхимын сургалт зохион байгуулж 16 албан хаагч хамрагдсан.



- Цахим хөгжил инновац харилцаа холбооны яамнаас 2025.03.29-нд зохион байгуулсан “Цахим хөгжил Харилцаа холбоо мэдээллийн технологийн Зүүн бүсийн чуулган-2025”-д хэлтсийн 4 албан хаагч оролцсон.
- УБЕГ-аас зохион байгуулсан “Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн”-нд 2025.03.31нд хэлтсийн дарга ахлах бүртгэгч нар оролцсон.
- Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-3 сургалтанд танхимаар 2025.04.02-ны өдөр бичиг хэргийн эрхлэгч хамрагдсан.



- УБЕГ МТГ-аас зохион байгуулсан “Мэдээллийн технологийн алба хаагчдийн нэгдсэн сургалт”-нд 2025.04.17-19 ны өдүүдэд мэдээллийн технологийн ажилтан хамрагдсан.
- МУЗГ, Аймгийн ЗДТГ-с 2025.05.02-03-нд зохион байгуулсан “Бүсчилсэн хөгжил төрийн албаны манлайлал зүүн бүсийн зөвлөгөөн”-нд 8 алба хаагч 2 өдрийн турш “Төрийн албаны хууль тогтоомжийн хэрэглээ”, “Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ”, “Төрийн албан хаагч эмэгтэйчүүдийн карьер хөгжлийг дэмжих, төрийн албан дахь удирдах түвшний жендэр”, “Дижитал төр AI Бүтээмж ба технологийн шийдэл”, “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системийн танилцуулга” зэрэг цогц сургалтуудад хамрагдсан.




- УБЕГ-аас зохион байгуулсан “Иргэний Улсын ахлах бүртгэгч нарын нэгдсэн сургалт”-ад 2025.05.12-13-ны өдрүүдэд 2 албан хаагч оролцсон.
- УБЕГ-аас зохион байгуулсан Спортын арга хэмжээнд 2025.05.26-ны өдөр 5 албан хаагч хамрагдаж Зүүн бүсийн эмэгтэй сагсан бөмбөг төрөлд “АЛТАН” медаль хүртсэн.
- Удирдлагын академи, аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан мэргэшүүлэх богино хугацааны багц сургалтад 5 албан хаагч хамрагдаж “СЕРТИФИКАТ” авсан.
- Нөхөн сонгуулийн итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах албан хаагчдад 2025.05.26-нд сонгуулийн тухай хууль, журмын танилцуулга сургалт



- Хэнтий аймгийн Цагдаагийн газраас 2025.05.28-нд “Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” Хэнтийнхэн залилуулахгүй нөлөөллийн арга хэмжээний хүрээнд сургалт
- Онцгой байдлын газраас 2025.06.12-нд “Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт
- МУЗГ, ОБГ, Хэнтий аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан “Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль - 2025”-ийн хүрээнд 15 удаагийн урт богино сургалтанд бүх албан хаагчид болон “Бүртгэл мэдээлэл, статистик судалгааны бүлэг” шуурхай штабын баг оролцсон.



- УБЕГазраас зохион байгуулсан Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем erp.e-mongolia.mn-ийн сургалтанд хэлтсийн дарга, бичиг хэргийн эрхлэгч нар хамрагдсан.



- Аймгийн ЗДТГ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан “Шинэ цахим өмчийн системийн сургалт” сургалтанд хэлтсийн 3 албан хаагч
- Удирдлагын академийн сургалтын нэгдсэн платформ цахим хаягт байршсан цахим хичээлүүд, Монгол бичгийн анхан, дунд, ахисан шатны сургалтанд хэлтсийн алба хаагчдийн 30% хамрагдаж сертификат авсан.



- МУЗГ, АЗДТГазраас зохион байгуулсан “Манлайлал ба инновац” сэдэвт 2 өдрийн танхимын сургалтанд 2025.11.3-4-нд 1 албан хаагч
- Гэр бүл хүүхэд хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас хамтран зохион байгуулсан “Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх сургалт” 2025.10.30-2025.11.03-ны өдөр 1 албан хаагч оролцон сертификат
- УБЕГ, ХЭУБГазраас зохион байгуулсан “Сумдын улсын бүртгэгч нарыг дадлагажуулах” сургалтын хөтөлбөрийн дагуу 2025.10.07, 2025.10.24-ны өдрүүдэд Хуулийн этгээдийн бүртгэлийг хөтлөхөд анхаарах асуудлын хүрээнд 2 өдрийн цахим сургалтанд давхардсан тоогоор 30 албан хаагч хамрагдсан.
- Хэнтий аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газар “Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх орон тооны бус комисс”-н тухай хэлтсийн албан хаагчдад
- УБЕГ, ЭХЭУБГазар “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, нотариатын зуучлалаар эрхийн улсын бүртгэл хөтлөхмэдлэг олгох тухай цахим сургалтанд 4 албан хаагч

Байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомж сурталчлах хүрээнд:

- Хэлтэс болон сум, тосгоны хэмжээнд нийт 7 удаа багийн өдөрлөг, 45 удаагийн багийн иргэдийн нийтийн хурал, албан хаагчдын сонсгол, цуглаан, “Явуулын хөтөч”-өөр дамжуулан давхардсан тоогоор 7370 иргэнд улсын бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээлэл өгч, бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж ажилласан байна.



- Аймгийн болон сум, тосгоны хэмжээнд 12 удаагийн ерөнхий боловсролын сургуулийн 439 сурагчид иргэний үнэмлэх шинээр авах талаар зохих мэдээлэл өгч ажилласан.



- Аймгийн хэмжээнд сумдуудад зохион байгуулсан “Хоршоологчдын зөвлөгөөн”, “Малчдын зөвлөгөөн”-д улсын бүртгэлийн чиглэлээр 7 удаагийн арга хэмжээнд давхардсан тоогоор 1288 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан.

- “Хэнтий намрын баяр-2025” 2025.09.11-нд зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр байгууллагын нээлттэй өдөрлөг зохион байгуулж 252 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.



- Бор-Өндөр суманд 2025.09.16-ны өдөр Нээлттэй өдөрлөг
- Бэрх тосгонд 2025.09.23-нд “Нээлттэй өдөрлөг” зохион байгуулж 193 иргэнд
- Аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан “Иргэдийн оролцоот Нэг Хэнтий” иргэдийн өдөр-2025 нээлттэй өдөрлөгт оролцож иргэнд зөвлөгөө мэдээлэл хүргэж бүртгэлийн үйлчилгээг сурталчилсан ажилласан.




2025.10.31-ний өдөр Дэлгэрхаан суманд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Саранцэцэг ажиллаж
Үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн бүртгэл 30, иргэн хуулийн этгээдэд 8 лавлагаа зөвлөгөө мэдээлэл, гарын авлага 38 иргэнд, 8 иргэнд газар дээр нь гэрчилгээг хүлээлгэн өгч нийт 104 иргэнд бүртгэлийн үйлчилгээ үзүүлж ажиллалаа.




3.3. Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажилласан талаар:

- Хэнтий аймгийн засаг дарга Д.Аюурбунь үйл ажиллагааны мөрийн хөтөлбөртөө улсын бүртгэлийн хэлтэст 30.0 төгрөгний санхүүжилт оруулна гэж заасны дагуу 2025.09.11-ний өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаатай танилцаж албан хаагчдад шаардлагатай 6 суурин компьютер, 2 зөөврийн нөтэбүүк, 1 гурван үйлдэлт өнгөт принтерийг гардуулан өглөө.



-Улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, зорилтот иргэдэд хүрч үйлчлэх зорилгын хүрээнд тус аймгийн 18 сумын удирдлагуудад зөөврийн төхөөрөмжийн талаар танилцуулга хийж, худалдан авах санал хүргүүлсний дүнд одоогоор 13 суманд зөөврийн тоног төхөөрөмж шийдүүлээд үйл ажиллагаандаа ашиглаж байна.

-Төрийн албаны шалгалтыг энэ оны 3, 5, 9,11 дүгээр сард зохион байгуулахад хурууны хээгээр иргэдийг таниулах ирц бүртгэлийг хийж ТАСЗ-тэй хамтран ажилласан.



-ШУТИС-ийн БУХИС-ийн Менежментийн ангийн оюутан Иргэний улсын бүртгэлийн тасагт 1 дүгээр сард 21 хоногийн дадлага хийсэн бөгөөд дадлагын удирдагчаар тус тасгийн Улсын ахлах бүртгэгч ажилласан. Дадлагын явцад хийсэн зарим нэг онцлох ажлаас дурьдвал иргэний шилжилт хөдөлгөөний талаар 10 асуумж бүхий судалгааг 100 иргэнээс авч нэгтгэн дүгнэлт гаргасан.

-ШШГГ-ын 419-р хорих ангитай 2025 онд хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан ажиллаж байгаа бөгөөд төлөвлөгөөний хүрээнд 7 хүмүүжигчийн гэрлэсний бүртгэлийг бүртгээд байна.



-Аймаг дахь Хүний эрхийн референт Ж.Ганбаяртай хамтран албан хаагчдад “Хүний эрх ба ёс зүй”-н талаарх зориулсан сургалт зохион байгуулсан. Сургалтыг оролцооны аргаар албан хаагчдад сонирхолтой байдлаар мэдээлэл өглөө. Мөн Хүний эрхийн комиссоос явуулж буй “Орон нутгийн иргэдийн хүний эрхийн нөхцөл байдалд хийх дүн шинжилгээ”-д сонгуулийн талаарх холбогдох мэдээлэл өгсөн.



-Хэрлэн сумын ЗДТГ-тай хамтран тус сумын зорилтот бүлгийн иргэдийн судалгааг гарган эдгээр иргэдээс хүсэлт авч улсын бүртгэлийн үйлчилгээг зөөврийн төхөөрөмжөөр хүргэхээр ажиллаж байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээгээр тусгагдсан тул цаашид явуулын үйлчилгээ үзүүлэх ажлыг эрчимжүүлж ажиллахаар тасгийн сар бүрийн хийх ажлын төлөвлөгөөнд оруулан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд одоогоор 35 иргэн үйлчилгээ аваад байна.



-“Дэлхийн гэр бүлийн өдөр”-өөр ГБХЗХГ-тай хамтран гэр бүл болж буй 10 хосын гэрлэх ёслолыг хамтран зохион байгуулсан.



-Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар, салбарын хөдөө орон нутагт ажиллаж буй алба хаагчид болон тэдний гэр бүлийн насанд хүрсэн гишүүдийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх, эрт илрүүлэг хийх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилго бүхий **"ХАМГИЙН ЧУХАЛ НЬ"** зорилтот арга хэмжээний 6 дугаар ээлжийн үзлэгт тус хэлтсийн албан хаагчид болон гэр бүлийн гишүүдийг 2025 оны 05 дугаар сарын 24-ны өдөр бүрэн хамруулсан.




-Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль 2025 онд Хэнтий аймагт зохион байгуулсантай холбогдуулан тус хэлтсийн албан хаагчид бүрэлдэхүүнээрээ оролцож нүүлгэн шилжүүлэх иргэдийн бүртгэлийг хийх ажлыг зохион байгуулсан.



-Политехникийн коллежийн 112 сурагчид иргэний улсын бүртгэлийн дугаарын мэдээлэл өгсөн.


-Бэрх тосгоны 2 Ерөнхий боловсролын сургуулийн 116 сурагч, Хэрлэн сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 200 сурагчдад иргэний үнэмлэх, тоон гарын үсэг, гадаад паспортын талаар мэдээлэл өгч, гарын авлага тараасан.



-ХХҮГ-ын ёс зүйн дэд хороотой хамтран туршлага судлах, уулзалт зохион байгуулсан.




-Аймгийн Боловсролын газрын мэргэжилтэнүүдтэй хамтран 85 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан Монгол бичгийн цэвэр бичигтэн, эссэ бичлэгийн уралдааны шалгаруулалтыг дүнг гаргасан.




-Соёл урлагийн газартай хамтран Улс тунхагласны өдрөөр “ИРГЭНИЙ АНДГАЙ” өргүүлэх ёслолын ажиллагааг зохион байгуулахаар удирдамж гарган бэлтгэл ажлыг хангаж байна.

-Хэнтий аймаг дахь “Голомт банк”-тай хамтран ажиллах гэрээ байгуулж тус банкнаас шинээр төрсөн харьяалал харгалзахгүй 200 хүүхдэд 100.000 төгрөгний хүүхдийн хадгаламж гардуулж хамтран ажиллах боллоо.



-“Жи тайм” сайт болон “Амжилтын ташуур” ХХК-тай тус байгууллагыг сурталчилан ажиллах хамтран ажиллах гэрээ байгуулж улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүх 85 жилийн ойд зорулсан видео, реелүүдийг хийж сурталчлан ажиллаж байна.



4.1. АНСДИТ-ийн нөхөн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, 9.9 дэх заалтын дагуу Хэнтий аймгийн Батноров сумын 6 дугаар баг, Батширээт сумын 4 дүгээр баг, Дархан сумын 1 дүгээр баг, Дэлгэрхаан сумын 3 дугаар баг, Норовлин сумын 4 дүгээр баг, Бор-Өндөр сумын 2, 3 дугаар багт тус тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулах тухай ИТХ-ын тогтоолууд гарсан.

АНСДИТХ-ын 2025 оны нөхөн сонгуулиар улсын бүртгэлийн хэлтсийн хэрэгжүүлэх 27 арга хэмжээ бүхий үйл ажиллагааны дэд төлөвлөгөө боловсруулж батлуулсан. Тус аймгийн 6 сумын ИТХТ-ийн сонгуулийн хэсэг байгуулсан тогтоолыг хүлээн авч улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд сонгуулийн хэсэг байгуулсан тухай тогтоол, сонгуулийн санал авах байрыг шивж оруулсан.

УБЕГ-ын даргын 2025.04.21-ны өдрийн А/71 дүгээр тушаалын дагуу иргэдийн засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлийг тус аймгийн 6 сум 7 багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2025.04.23-ны өдрөөс санал авах өдрийг дуустал хугацаанд түр зогсоосон.

Хуульд заасны дагуу холбогдох 6 байгууллагаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн сонгогчдын нэрийн жагсаалтад нэмэлт тэмдэглэгээ хийснийг нягтлан шалгахад эрх зүйн чадамжгүй нь шүүхээр тогтоогдсон 1 сонгогч, хорих ангид ял эдэлж байгаа 12 сонгогч, Тусгай ангийн албан хаагч, ажилтан 3, цагдаагийн албан

хаагч,ажилтан 3 сонгогчийн мэдээлэл үнэн зөв байна. Харин гадаадад 60 ба түүнээс дээш хоногоор зорчсон сонгогчийн хувьд 169 иргэн нэмэлт тэмдэглэгээ хийгдсэн боловч 19 сонгогч нь байнга оршин суугаа хаягтаа одоо байгаа иргэд байв. Одоогийн байдлаар гадаадад 60-аас дээш хоногоор зорчсон гэх үндэслэлээр түр хасав нэмэлт тэмдэглэгээ тавигдсан 4 сонгогч мэдээллээ сэргээлгэхээр хүсэлт гаргаж тухай бүр шийдвэрлэн ажилласан.

Тагнуулын байгууллагын зөвшөөрлөөр 7 сонгуулийн хэсэгт ажиллах 7 итгэмжлэгдсэн ажилтантай ажиллах гэрээг байгуулж. Итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүйн сургалтыг зохион байгуулсан.

2025.05.26-ны өдөр СНЖ-ыг 2 хувь хэвлэж сонгуулийн 7 хэсгийн хороонд хүргэх ажлыг амжилттай зохион байгуулсан. Санал авах өдөр 2002 сонгогч саналаа өгч 38.32 хувьтай санал хураалт дууссан.

4.2. Орон нутгийн зохион байгуулсан ажлын талаар

Газар хөдлөлтийн аюулыг иргэд олон нийтэд таниулах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дуут дохиогоор цугларах Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор жил бүрийн гуравдугаар сарын гурав дахь долоо хоногийн пүрэв гарагт 16:00 цагт гамшгийн зарлан мэдээллийн дуут дохио дуугаргадаг ба иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд онцгой байдлын газрын заавар зөвлөмжийн дагуу гамшгаас хамгаалах дадлага, сургуулилтад хамрагдсан



Бүх нийтийн хог цэвэрлэгээний өдөр байгууллагын эзэмшлийн гаднах 50-100м талбайн хогийг, Нэг байгууллага нэг саад аяны хүрээнд Хэрлэн голын сав хэсгийг цэвэрлэж 3-р багийн хог ачилтын машин дуудаж ачуулсан.





Улсын бүртгэлийн хэлтсийн ногоон төгөл бий болгох зорилгоор 1 га газарт 165 ширхэг шар хуас, улиас тарьж ногоон байгууламж бий болгосон. Хэлтсийн гадна талбайд 150 ширхэг шар хуас модыг хашаажуулж, цэцгийн мандалд цэцэг үрслүүлэн, 3 нарс мод суулгаж, 52 м газар зүлэгжүүлсэн.





Хэлтсийн гадаах



2025.05.17



2025.10.15



Д/ Д	Байршил	Модны төрөл	Тоо хэмжээ	Хариуца х байгуул лага	Одоогийн байгаа нөхцөл байдал, цаашид хийгдэх ажлын тухай
1.	Хариуцсан цэцэрлэгт хүрээлэн	Улиас	13	Улсын бүртгэли йн хэлтэс	Шинээр 10ш улиас тарьж өмнө тарьсан моднуудаа усалж тордсон. Үхэжсэн 3 модыг шинээр сольж тарьсан.
2.	Хариуцсан газар /Хот явах зам дагуу 491-507 шон/	Шар хуалс	100		Шинээр газар ухаж 100ш Шар хуалс тарьж усалсан
3.	Хэлтсийн гадна	Шар хуалс, нарс, цэцэгжү үлэлт	150, 3, 200		Шинээр 50ш шар хуалс байгууллагын гадна газар ухаж тарьж усалсан.
4.	Гэлэн хөшөө хашаа	Шар хуалс	50		Шинээр газар ухаж 50ш шар хуалс тарьж усалсан
	Нийт тарьсан модны тоо		316		

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг баримтлан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Хэлтсийн албан хаагч, сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан эрхээ хэрэгжүүлэн ажиллаж байна. Дараах саналыг хүргүүлж байна.

Бүртгэлийн хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд:

1. Хэлтсийн байр ашиглалтад ороод 5 жил болж гадна пасадны өнгө будаг гандсан тул сэргээн засварлах зардлыг шийдвэрлэж өгнө үү
2. Сум орон нутагт явуулын үйлчилгээг үзүүлж байгаа албан хаагчид хувийн унаагаар явж буй тул албанд авто машин шаардлагатай.

Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, чадавхжуулах хүрээнд:

1. Хөдөлмөрийн дотоод журамд заасан тусламж дэмжлэгийг тогтоосон хэмжээгээр олгоход шаардагдах төсвийг бүрэн тусган батлуулах
2. Албан хаагчдыг чадавхжуулах сургалт /гадаадад болон дотоодод давтамжтай/

ТАЙЛАН БИЧСЭН:
УЛСЫН АХЛАХ БҮРТГЭГЧ

Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ТӨРХҮҮ